

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Ар
жанчивлан рашаан сувилал” ХХК-ний
“Ар жанчивлан рашаан сувилал”



2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга	2
2. Төслийн талбай, түүний байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	5
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	6
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	7
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	10
4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	10
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	10
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10
4.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10
4.7. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх хуваарь	11
4.8. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ	11
4.9. БОМТ болон түүний хэрэгжилтийг оролцогч сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	11
4.10. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	12

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “Ар жанчивлан рашаан сувилал” ХХК

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил: “Ар жанчивлан рашаан сувилал” нь Төв аймгийн Эрдэнэ сумын 1-р багийн нутаг дэвсгэрт, Улаанбаатараас 60 км, Налайхаас 28 км-т, Монголын 3 том нурууны нэг Хан-Хэнтий уулын мөнх цэвдэгт нурууны урд үзүүрт, байгалийн үзэсгэлэнт сайхан Баянцогт уулын орчимд байрладаг.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих газрын байршлын координат

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1.	5287169,81	688889,99	6.	5287046,77	689123,00
2.	5287425,16	688995,99	7.	5287048,56	689101,18
3.	5287376,77	689250,40	8.	5287071,51	689100,06
4.	5287330,17	689299,54	9.	5287080,38	689037,70
5.	5287097,49	689332,34	10.	5287076,75	688922,61



Зураг 1. Сувиллын ерөнхий байршлын зураг




Зураг 2. Төсөл хэрэгжүүлж буй газрын орчны тойм зураг

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Сувиллын орчны өнөөгийн байдал

Байгалийн тулгуур шинжтэй хамгийн том объект бол газар юм. Газрын төлөв байдал, шинж чанараас бусад объект ихээхэн шалтгаалах тул тэр нь тодорхой хэмжээгээр анхдагч шинж чанартай юм. Тус сувилалын хувьд 1973 оноос хойш сувиллын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Одоогийн байдлаар сувилал нь 60 гаруй ажилчидтай, хоногт 200 – 250 хүнийг өөрийн эзэмшлийн 12.1 га талбайд хүлээн авч үйл ажиллагаагаа явуулж байна. Иймээс тухайн газар нутаг нь хүний үйл ажиллагааны улмаас тодорхой хэмжээгээр газрын гадаргын элэгдэл эвдрэлд орсон байна.

Уг сувиллын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа барилга, байгууламж нь дараах үндсэн болон туслах барилга байгууламжаас бүрдэнэ.



Зураг 3. Сувиллын талбай дээрх барилга байгууламжуудын схем зураг

Сувиллын объектуудыг эзлэх талбайтай нь жагсаавал дараахь байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Сувилалын эдэлбэр газрын ашиглалтын талбай

№	Ашиглалтын талбайнууд	Талбай, м ²
1.	Сувиллын барилгууд	3123.45
2.	Соёлын төвийн нэг давхар барилга	200.0
3.	Шороон зам	1800.0
4.	Ажилчдын сууц	300.0
5.	Нам даралтын зуухны барилга, нүүрс хадгалах хэсэг болон өргөтгөлийн зуухны барилга	48.0
6.	Рашааны худаг, барилгын хамт	7.8
7.	эмчилгээний байр	172.1
3.	Нарны халаалттай халуун усны газар	162.0
9.	Гараж	300.0

“Ар жанчивлан рашаан сувилал” ХХК

10.	Агуулах	242.0
11.	Зуны гал тогоо	195.0
12.	Зуны п хэлбэрийн байр	272.0
13.	Зуны дугуй байр	78.6
14.	Зуны шовгор байр, 5 ш	120.0
15.	Зуны дөрвөлжин байр, 5 ш	146.25
16.	Цэвэрлэх байгууламж	1800.0
17.	Хатуу хаягдал түр хадгалах цэг	70.0
	Дүн	9037.2
18.	Чөлөөт талбай (газар ашиглах зөвшөөрөлтэй нийт талбайгаас)	111962.8
	Нийт	121000.0

2.2. Сувиллын орчны нийгэм, эдийн засгийн хөгжил

Тус сувилал нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг, Эрдэнэ сумын төвөөс 25 км зайд оршдог. Налайх дүүргийн эрчим хүчинд холбогдож, гэрэл цахилгааны асуудал нь бүрэн шийдэгдсэн. Үүрэн телефон утасны бүх сүлжээ чөлөөтэй холбогдоно. Өөрийн цэвэр усны худагтай. Эрдэнэ суманд сүүлийн үед жуулчдын анхаарлын төвд байгаа Чингис хааны хөшөөт цогцолбор, 13-р зууны аж амьдралыг харуулсан жуулчны бааз, Гүнжийн сүм зэрэг олон түүх, соёлын дурсгалт газрууд болон Ар жанчивлан, Өвөр жанчивлан зэрэг эрүүл мэндийн сувиллын газрууд бий. Ар жанчивлангийн рашаан сувиллаас Өвөр жанчивлан рашаан сувилал нь 18 км зайтай.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх болзошгүй нөлөөллийг үнэлэхдээ өмнө хийгдсэн судалгаа болон экспертүүдийн дүгнэлт, газар дээрхи судалгаа шинжилгээнд үндэслэн боловсруулав. "Аржанчивлан рашаан сувилал" төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойллоо.

Хүснэгт 3. Төслийн зүгээс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх гол сөрөг нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны хүчин зүйлс	Нөлөөллийн түвшин	Тайлбар
Ус		
Гадаргын ус	Дунд	Аржанчивлан рашаан эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос хамгаалах арга хэмжээ аваагүйгээс рашаан, усны нөөц нь хомсдох, бохирдох зэргээр ихээхэн хэмжээний, урт хугацааны сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм. Нөхөн сэргээгдэх боломжгүй, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хамгаалалтыг сайжруулах, ашиглалтыг хянаж, сувиллын болон орон нутгийн зүгээс системтэй арга хэмжээнүүдийг авч ажиллах.
Рашаан		
Газрын доорхи усны нөөц	Дунд	Газрын доорхи усны нөөц аажимдаа багасаж байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Сувиллын үйл ажиллагаанаас уст давхарга удаан хугацааны нөлөөлөлд өртөнө, нөхөн сэргээгдэх боломжгүй, орчны хяналт шинжилгээг тогтоосон хугацааны дагуу хийлгэж байх шаардлагатай.
Хөрс		
Хөрсний элэгдэл, эвдрэл	Дунд	Машин техникийн механик үйл ажиллагаа болон хүний хүчин зүйлээс үүдэлтэйгээр хөрсөн бүрхэвчид удаан хугацаагаар сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Нөхөн сэргээгдэх боломжтой. Хөрс хамгаалах, нөхөн сэргээх талаар иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
Агаар		
Агаарын чанар	Бага	Сувиллын үйл ажиллагаанд ашиглагддаг болон

“Ар жанчивлан рашаан сувилал” ХХК

		сувилуулагчдын ирэх автомашины яндан болон уурын зуухнаас гарах хорт хий болон хог хаягдал агаар орчинд богино хугацааны бага зэргийн нөлөөлөл үзүүлж болзошгүй. Уурын зуухны янданд хорт хийг шүүх шүүлтүүр суурилуулж, хянах шаардлагатай.
Ургамал, амьтан		
Ургамал	Дунд	Сувилалд сувилагчдын хэт их төвлөрөлтөөс үүдэлтэй ургамлан бүрхэвчид их хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Нөхөн сэргээгдэх боломжтой. Сувиллын ойр орчим, цэвэрлэх байгууламжийн дэргэд, рашааны хамгаалалтын бүст ногоон бүс байгуулах, тохижуулах
Амьтан	Дунд	Хүний хэт төвлөрөлт, тухайн орчинд тархах дуу чимээ, машин техникийн хөдөлгөөнөөс амьтанд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Аль болох задгай агаарт оройн цагаар үдэшлэг, цэнгүүн зохион байгуулахгүй байх, эзэмшил газрыг бүхэлд нь гэрэлтүүлэхээс зайлсхийх.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Ар жанчивлан рашаан сувилал” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.

Ерөнхий зүйл. Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн (цаашид төсөл хэрэгжүүлэгч гэх) байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газарт хүргүүлэн хянуулж, батлуулна. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)
- ✓ Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө. Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- ✓ Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө
- ✓ Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө
- ✓ Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“

“Ар жанчивлан рашаан сувилал” ХХК

- ✓ Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- ✓ Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- ✓ Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт
- ✓ БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт зэргээс бүрдэнэ.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахарга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар									
1.	Сувиллын газрын орчны хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт нь агаарын чанарын найрлагын эх үүсвэр болно	Төсөлд ашиглагдах тээврийн хэрэгслийн тохиргоо үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх	Сувиллын орчин	мг/м³	250.0	-	250.0	2026 оны 5, 9-р саруудад	MNS 4585:2025, Агаарын чанарын тухай стандарт
2.	Ахуйн хог хаягдлын сав болон бохирын цооногийн битүүмжлэл алдагдах, шатах тослох материалын ууршилт зэргээс аргаар дахь тоосжилт, PM, CO, SO2, NO2 ихсэж хүчилтөрөгчийн хэмжээ багасаж болзошгүй	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, гэрээний дагуу зайлуулж байх	Сувиллын орчин	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан				Сард 1 удаа /ачааллын үед 14 хоногт 1 удаа/	MNS 4585:2025, Агаарын чанарын тухай стандарт Хог хаягдлын тухай хууль /2017 он/
Хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар									
3.	Машин техникийн механик хөдөлгөөн болон хүний хэт их төвлөрөлтэй холбоотойгоор хөрс, ургамлан бүрхэвч бохирдож, элэгдэл, эвдрэлд орох	Сувиллын орчны хөрсний шинжилгээг жилд 2 удаа хийлгэх	Сувиллын эдэлбэр газарт	Орчны хяналт шинжилгээ хийх хөтөлбөрт тусгасаны дагуу			2026 оны 5, 9-р саруудад	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850-2019 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990	
		Сувиллын үйл ажиллагаанаас үүссэн ахуйн хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж байх	Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал	Гэрээний дагуу			Сард 1 удаа /ачааллын үед 14 хоногт 1 удаа/	Хог хаягдлын тухай хууль /2017 он/, Хог хаягдлыг ангилан ялгаж хаях тухай журам	

“Ар жанчивлан рашаан сувилал” ХХК

		Одоо байгаа ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж нийт 200 м ² талбайд ногоон байгууламж байгуулах	Төслийн талбайд 200м ² талбайд	Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу				2026 оны 9-р сард	MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага MNS 5916:2008 Газар шорооны үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар									
5.	Рашаан болон ундны ус нөөцлөх сангийн байрны цэвэрлэгээ, ариутгалыг дутуу хийснээс рашаан, ундны ус бохирдох	Ундны ус болон рашааны нөөцлөх сангаас усны дээж авч шинжлүүлж байх	Сувиллын эдэлбэр газар болон рашааны нөөц бүхий талбайн орчимд	Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөнд тусгасан				2026 оны 5, 9-р саруудад	Усны 22-р зүйл ба бусад зүйл MNS 0900:2018 Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
		Ундны ус болон рашааны нөөцлөх сангаас усны дээж авч шинжлүүлж байх	Ундны ус болон рашаан	ОХШХ-т тусгасанаар				2026 оны 5, 9-р саруудад	Усны тухай хууль 3-бүлгийн 22-р зүйл ба бусад зүйл, бусад хууль, журам, стандарт
6.	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдож бохир усыг стандартад нийцүүлэхгүйгээр байгальд алдвал сувиллын ойролцоох усан хангамж, амьтан, ургамал, ундны усны бохирдол бий болж болзошгүй	ЦБ-ын үйл ажиллагаанд байнга хяналт тавих, бохир усны хяналтын худгаас дээж авч шинжлүүлж	Бохир ус цэвэрлэх байгууламж	ОХШХ-т тусгасанаар				2026 оны 5, 9-р саруудад	MNS 4288:1995. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих шаардлага. MNS 4943:2015. Усны чанар. Хаягдал ус.
		Бохир усны худгуудад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг ариутгалын бодисоор хийж байх	Бохир ус цэвэрлэх байгууламж, түүний орчин	-	250.0	-	250.0	Улиралд тутамд /2026 оны 3,6,9,12 саруудад/	
Нийт				-	-	500.0	-	-	

4.2. Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө

Сувиллын зүгээс ногоон байгууламжийн хэмжээг нэмж өргөтгөх зорилгоор 2026 онд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэр бум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн 200 м² талбайд ногоон байгууламж байгуулах.

Хүснэгт 4.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
Сувиллын ногоон байгууламжийн хэмжээг нэмж өргөтгөх, Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан тэр бум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод, суулгац тарихаар төлөвлөсөн	Одоо байгаа ногоон байгууламж дээрээ нэмээд 200м ² талбайд Нарс, буйлс тарьж ургуулна.	Сувиллын орчинд	1400.0	2026 оны 9-р сард	MNS 5918:2023, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 6260:2011 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих арчлах
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний нийт зардал			1400.0	-	-

4.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртсөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлын тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг хийх шаардлагагүй болно.

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн үйлчилгээ болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй болно.

4.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний арга хэмжээний зардал

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлыг зориулалтын саванд хадгалах, ангилан ялгах, хог хаягдлын талаархи боловсрол олгох асуудлыг авч хэрэгжүүлэх, ажилчдын дунд сургалт зохион байгуулах, байгальд ээлтэй соёл хэвшүүлэх, хог хаягдлыг зүй зохистой хаях, ангилах, дахин ашиглах дадал зуршлыг төлөвшүүлэх зэргийг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах шаардлагатай.

Хүснэгт 5.

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Зардал мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлын цэг, хог хаягдал ангилан ялгах талбай, сувиллын орчимд бохирдол	Хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх	Улирал бүр /2026 оны 3,6,9,12 саруудад/	1200.0	Хог хаягдлын тухай хууль
	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Сар бүр		

үүсгэж болзошгүй	Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт зөөж зайлуулж байх	Сар бүр	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр	MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
Нийт зардал /мян.төг/			1200.0	-

4.7. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хүснэгт 6.

№	Хийгдэх ажлын нэр төрөл	Хийгдэх шаардлага	Хийх хугацаа	Ажлын хэмжээ	Шаардагдах хөрөнгө
1.	Байгаль орчныг хамгаалах асуудлаар жил бүрийн тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг тухайд нь гаргаж өгөх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу	2026 оны 1-р улиралд	Жил бүр БОМТ төлөвлөгөөг боловсруулж батлуулах	-
2.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэх	Хуульд заасаны дагуу байгаль орчны аудит хийлгэх	2026 оны 3-р улиралд	Эрх бүхий аж ахуй нэгжээр	Гэрээний дагуу
3.	Хог хаягдлын талаар боловсрол олгох сургалтыг мэргэжлийн хүмүүсээр зохион байгуулах	Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагаас сургалт авах	Улирал тутам	Байгууллагын хэмжээнд дотоодын сургалт	Дотоод зардлаар
4.	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлж байх	Гэрээний дагуу	Сар бүр	Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Гэрээний дагуу

4.8. БОМТ болон түүний хэрэгжилтийг оролцогч сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Хүснэгт 7.

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүл-гээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Төв аймгийн байгаль орчны газрын дарга	БОМТ хэрэг- жилтийн жилийн тайланг бичгээр	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	Төв аймгийн Байгаль орчны газар
Төв аймгийн байгаль орчны газрын ахлах мэргэжилтэн	БОМТ хэрэг- жилтийн жилийн тайланг бичгээр	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	Төв аймгийн Байгаль орчны газар

Төв аймгийн байгаль орчны газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч	БОМТ хэрэг-жилтийн жилийн тайланг бичгээр	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	Төв аймгийн Байгаль орчны газар
Төв аймгийн байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн	БОМТ хэрэг-жилтийн жилийн тайланг бичгээр	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	Төв аймгийн Байгаль орчны газар
Төв аймгийн Эрдэнэ сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч	БОМТ хэрэг-жилтийн жилийн тайланг бичгээр	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	Төв аймгийн Эрдэнэ сум
Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл	БОМТ хэрэг-жилтийн жилийн тайланг бичгээр	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	Төв аймгийн Эрдэнэ сумын 1-р баг
БОУАӨЯ	БОМТ хэрэг-жилтийн жилийн тайлан /цахимаар/	БОМТ-ний заалт тус бүрээр хэрэгжилтийн байдлыг тодорхой бичнэ	2026 оны 11-12-р сард	БОМТ хэрэг-жилтийн жилийн тайлан /цахимаар/	Цахимаар

5. Байгаль орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

“Ар жанчивлан рашаан сувилал” төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, байгаль орчны доройтол, гэнэтийн бохирдлыг хянах, бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор байгаль орчны мониторингийн үйл ажиллагааг явуулна. Мониторинг нь байнгын ажиглалт шинжилгээгээр гарсан үзүүлэлтүүдийн хяналт тэдгээрийн үнэлгээ болон хэтийн төлөв байдлыг урьдчилан таамаглах зэрэг үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг хяналт, төлөвлөгөөтэй, цэгц явуулахын тулд “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” (ОХШХ)-ийг боловсруулан мөрдөнө.

Орчны бохирдлын байдлын ажиглалт, хяналтыг орчны дээжид хийсэн тоон болон чанарын шинжилгээний үр дүнд үндэслэн явуулна. Шинжилгээгээр гарсан үр дүнг стандартын дагуу батлагдсан ЗДА-тай харьцуулан орчны бохирдлын бие даасан үнэлгээ хийх бөгөөд уг ажлыг хөнгөвчлөхийн тулд тусгай эрх бүхий төрийн байгууллагуудаар батлагдсан ББ-уудын нормативуудыг энэхүү тайланд оруулав.

5.1. Байгаль орчны хяналт шинжилгээнд ашиглагдах норматив үзүүлэлтүүд

Хүснэгт 8. Агаар дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Бохирдуулагч бодис	Хортой нөлөө үзүүлэх хэмжээ мг/м3	Ажлын бүсийн ЗДА мг/м3	Хүн ам орших бүсийн ЗДА мг/м3	Үнэр	Аюулын зэрэг
1.	Азотын давхар исэл	0,09	0,085	0,04	Хурц	2
2.	Нүүрстөрөгчийн давхар исэл	5	-	3	-	3

3.	Тоос	0,5	-	0,2	-	3
----	------	-----	---	-----	---	---

Хүснэгт 9. Хөрсөнд байж болох хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Бохирдуулагч бодис	Зөвшөөрөгдөх дээд агууламж, мг/кг
1.	Нефть, нефтийн бүтээгдэхүүн	0
2.	4 этилт хар тугалга	0
3.	Хар тугалга	0,8
4.	Бензол	0,3
5.	Бензин	0,1
7.	Pb+2	6,0
8.	Hg+2	2,1
9.	Cu+2	3,0
10.	Пирит	0,0

Хүснэгт 10. Гадаргын усанд байж болох бохирдуулагч болон хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Найрлага	ЗДА, мг/л	Хөнөөлийн хязгаарлагч үзүүлэлтүүд (ХХҮ)
1.	Жинлэх бодис	Тавих усан дахь фоны хэмжээ + 0,25 мг/л	
2.	Ууссан хүчилтөрөгч	6	
3.	Хлоридууд	300	Эрүүл ахуй - токсикологийн
4.	Сульфатууд	100	Эрүүл ахуй - токсикологийн
5.	ХХХ	15	
6.	БХХ5	2 (БХХбүрэн.)	
7.	Аммоны азот	0,39	Токсикологийн
8.	Нитритын азот	0,02	Токсикологийн
9.	Нитратын азот	9,1	Эрүүл ахуй - токсикологийн
10.	Фосфатууд	0,61	Ерөнхий эрүүл ахуйн
11.	Ерөнхий төмөр	0,1	Токсикологийн
12.	Зэс	0,001	Токсикологийн
13.	Хром (III)		Токсикологийн
14.	Фенолууд	0,001	Загасны аж ахуйн
15.	Нефтьбүтээгдэхүүн	0,05	Загасны аж ахуйн
16.	Анион идэвхит НГИБ (нийлэг-жүүлсэн гадаргуу идэвхит бодис)	0,1	Токсикологийн

Хүснэгт 11. Ундны усанд байж болох бохирдуулагч болон хорт бодисын зөвшөөрөгдөх дээд агууламж /ЗДА/

№	Найрлага		Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх агууламж
1.	Орга-но-леп-тик	Өнгө	-	Өнгөгүй
2.		Үнэр	-	Үнэргүй
3.		Амт	-	Амтгүй
4.	Эрдэсжилт		г/л	1,0
5.	Хатуулаг		мг*экв/л	7,0
6.	Төмөр		мг/л	0,3
7.	pH		-	6,5-9,5
8.	Нитрат		мг/л	50,0
9.	Мик-ро-биологи	Колииндекс		Байхгүй
10.		Микробын ерөнхий тоо (МЕТ)	ш	50,0

5.2. Орчны хяналт шинжилгээ хийх хөтөлбөр

Хүснэгт 12.

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаар	Агаар дах нийт тоосжилт	мкг/м³	Жилд 2 удаа (5,9 саруудад аль нэгэнд)	Сувиллын эзэмшил талбайд (бүх төрлийн хог хаягдлын цэг, автомашины зогсоол) (2 цэгт * 2 дээж)	240.0	480.0	Агаараас сорьц авах, агаар дахь хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлох, агаар дахь азотын давхар ислийн агууламжийг тодорхойлох MNS 4585:2025, Агаарын чанарын стандарт Агаар мандал, сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS: 3384-82
	Агаар дахь хорт хийн агууламж CO ₂ , SO ₂ , NO ₂ , O ₃ , CH ₄ , NH ₃				(Автомат анализатор-аар хяналт шинжилгээ хийх)		
Ус	pH, Нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, Fe, NH ₄ , SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃ , Ni-ийн агууламж, амт, үнэр, өнгө, тунгалаг, тунадас	мг/дм³	Жилд 2 удаа (5, 9-саруудад)	Ундны усны эх үүсвэр түүний орчин, рашааны эх үүсвэрийн орчин	120.0	240.0	УСТ-3534-83 “Усны шинжилгээнд дээж авах арга, химийн шинжилгээний стандарт. “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 900:2005”, “Усан орчны чанарын үнэлгээ MNS 4685:98”
	Газрын доорхи болон хөрсний усны түвшин, бохирдол			Сувиллын ойролцоох гол (1 цэгт *1 дээж), бохир усны хяналтын худгаас			
Хөрс	Ялзмаг Урвалын орчин-pH Карбонат Хөдөлгөөнт фосфор, кали (P2O5, K2O) Цахилгаан дамжуулах чанар	мг	Жилд 2 удаа (5, 9 саруудад)	Бүх төрлийн хог хаягдлын цэг, цэвэрлэх байгууламжийн (2 цэгт *4 дээж)	90.0	180.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850-2019 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990
	Механик бүрэлдэхүүн Чулуу						
	Хүнд металлууд Pb, Co, Ni, Cr, Cd						
Нийт						900.0	-

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 4000.0 мян.төг зарцуулахаар төлөвлөв.

2026 онд БОМТ-нд төлөвлөсөн ажлын зардал

№	Төлөвлөгөөний төрөл	Мөнгөн дүн, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
2	Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө	1400.0
3	Хог хаягдал	1200.0
4	Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө	900.0
Нийт дүн		4000.0

Ар жанчивлан рашаан сувиллын БОННУ-ний тайлангийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022-2026 онуудад тусгасан төлөвлөгөөний төсөв болон гүйцэтгэлийн тайлан



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ 2022-2026

№	Хугацаа	Ангилал	Төсөв	Төлөөлөгдсөн нийт төсөв	Нийт Гүйцэтгэл
1.	2022 он	Сөрөг нөлөөллийг бууруулах	1,800,000	8,470,000	35,820,000
2.		Ногоон байгууламж	5,000,000		
3.		Хог, хаягдал, хаягдал ус	1,000,000		
4.		Шинжилгээ	670,000		
5.	2023 он	Сөрөг нөлөөллийг бууруулах	1,800,000	9,382,000	35,820,000
6.		Ногоон байгууламж	5,000,000		
7.		Хог, хаягдал, хаягдал ус	1,200,000		
8.		Шинжилгээ	1382000		
9.	2024 он	Сөрөг нөлөөллийг бууруулах	1,800,000	14,032,000	12,858,675
10.		Ногоон байгууламж	10,000,000		
11.		Хог, хаягдал, хаягдал ус	850,000		
12.		Шинжилгээ	1,382,000		
13.	2025 он	Сөрөг нөлөөллийг бууруулах	1,350,000	4,450,000	20,623,000
14.		Ногоон байгууламж	2,000,000		
15.		Хог, хаягдал, хаягдал ус	200,000		
16.		Шинжилгээ	900,000		
17.	2026 он	Сөрөг нөлөөллийг бууруулах	500,000	4,000,000	
18.		Ногоон байгууламж	1,400,000		
19.		Хог, хаягдал, хаягдал ус	1,200,000		
20.		Шинжилгээ	900,000		
	Нийт			40,334,000	105,121,675

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД
ТУСГАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

№	Хугацаа	Ангилал	Төлөвлөгдсөн төсөв
1.	2022-2026	Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	9,870,000
2.	2022-2026	Орчны тохижилт ногоон байгууламжийн төлөвлөгөө	7,170,000
3.	2022-2026	Орчны хяналт, шинжилгээ	1,382,000
4.	2022-2026	Хог хаягдлын менежмент	1,200,000
	Нийт		19,622,000

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.УНДРАХ